



СЭЛЭНГЭ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/43

Сант сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэн хийгдэж буй “Төв талбайг засварлах” ажлын гүйцэтгэлд хяналт тавих, хүлээн авах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Сэлэнгэсайхан  
(Ивэн багийн Засаг дарга)  
Гишүүдэд: Ц.Батсайхан  
(Газрын даамал)  
Д.Адилбиш  
(Төрийн үйлчилгээний оператор, нярав)

2.Ажлын гэрээний үүргийн биелэлтийн чанар болон гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Сэлэнгэсайхан)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (А.Одхүү)-д үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: *З. Оюун Ариун*  
Хянасан: *В. Г. Ариун*  
Хувь: *2*  
Огноо: *2023.04.10*